

ХУБИЛАЙ ХААН БА ЮАНЬ УЛСЫН НИЙСЛЭЛ

Д.Наран

МУИС-ийн Гадаад Хэл, Соёлын Сургууль

Өгүүллийн товч утга: Хубилай хаан хятад газар сууж тэнд нийслэл байгуулсан учир шалтгаан, манай түүхчид уг асуудлыг хэрхэн үнэлж дүгнэсэн асуудлыг хөндөж шалтгааныг өнөөгийн өндөрлөгөөс бус, харин тухайн үеийн нөхцөл байдал, нийгмийн ухамсар, хувь хүний оюунлиг талаас тайлбарлахыг зорьсон болно.

Түлхүүр үг: оюунлиг, Хар Хорум, Жунду, Ухуань, Сяньби, соёрхол, байлдан дагуулал

Одоогоос 800 гаруй жилийн тэртээ монголчууд мөнх тэнгэрийн хүчинд бишэрч, “тэнгэрээс буулгасан ташуур” хэмээгдэж, ертөнцийн олон улсыг байлдан дагуулсаны үр дүнд Ази, Европыг дамнасан их гүрний эзэн улс болсон түүхтэй.

Ертөнцийг төвшитгөх гэсэн Чингис хааны их үйл хэргийг хөвгүүд ач нар нь үргэлжлүүлж, ач хүү Хубилай 1260-аас 1294 оны хооронд 34 жил төрийн жолоо атгахдаа нангиадын Өмнөд Сун улсыг бүрэн эрхэндээ оруулсанаар тухайн цагтаа хамгийн олон хүн амтай, олон үндэстэн ястанг харьяандаа нэгтгэсэн хэт их гүрний эзэн хаан байсан гэдгийг үгүйсгэх аргагүй юм. Эдүгээ зарим эрдэмтэн судлаачид Хубилай Монгол гүрний нийслэл Хар Хорум хот байсныг өөрчлөн өмнө тийш хятад газар шилжүүлж алдаатай буруу үйлдэл хийсэн гэж шүүмжилдэг бол зарим нь өөр байр сууринаас эерэгээр ч үнэлж дүгнэсэн байдаг. Үүнийг бичигч энэхүү өгүүлэлдээ эдгээр эрдэмтэн мэргэдийн дүгнэлтийг үгүйсгэх, няцаах зорилт тавиагүй, харин Хубилай хаан Хар Хорумд суулгүй яагаад Хаанбалгас (Дайдү) хэмээх нийслэл байгуулж тэндээ сууж улс орныг удирдах болсон нөхцөл шалтгааныг өнөөгийн өндөрлөгөөс бус, харин тухайн үеийн нөхцөл байдал, нийгмийн ухамсар, хувь хүний оюунлиг талаас тайлбарлахыг зорьсон болно.

Эхлээд эрдэмтэн судлаачдын тайлбар дүгнэлтийг авч үзэх нь зүйтэй болов уу. Академич Ч. Далай багш Хубилайн дээрх үйлдлийг монголын феодалууд эхлээд Хятадыг эзлээд цааш Япон, Вьетнам, Энэтхэг, Индонези зэрэг олон улсыг түрэмгийлэн эзлэх зорилго, улс төр, эдийн засгийн бодлоготой холбож мөн хятадыг

эзлэн захирах шаардлагаас үүдэлтэй гэж үзсэн¹. Доктор Г.Сүхбаатар байр сууриа илэрхийлэхдээ "Хубилай хятад цэргийн дэмжлэгтэйгээр Аригбөхийг дийлэн, Хар Хорумыг эзлэн захын хот болгоод Хятадад Монголын Юан улсыг байгуулан, улсын төвийг хятад нутагт аваачин, Монгол улсыг сүйрлийн замд нь оруулсан билээ"² гээд мөн "Юань улсын хаан Хубилай эмс, хятад эдийн шуналд автагдсаар эцэстээ төрийнхөө эрх ашгаас урван, монгол угсаатан, Монголын төрийг олон зуун жилийн хямралд оруулсан"³, "Их Монгол улс Чингис хаанаас хойш Өгэдэй, Гүюг, Мөнх хааны үеийн байдлаар БНМАУ-ын нутагт төвлөн оршин тогтнож хөгжсөөр байх бүрэн боломжтой байсан. Их Монгол улс тийнхүү хөгжсөнсөн бол хүчээ алдаж, манж нарт эзлэгдэн 200 жил колоничлогдохгүй байх байсан"⁴ гэжээ. Түүхч А. Амар "...Хубилай цэцэн нанхиад орныг захирч удирдахад ойр дөхмийг бодож одоогийн Бээжин хотыг байгуулж, тэнд шилжин нийслэлсэн", ..." Хубилай цэцэн хаан улсын нийслэлийг нанхиад дотор байгуулсан нь нанхиадын аюулыг нанхиад дотор сэргийлсэн бөгөөд чухамдаа жинхэнэ өөрийн Монгол орныг ямар ч аюул хямрал учруулалгүйгээр сахин хамгаалж байсан ажгуу" гэжээ⁵.

Академич Ж.Болдбаатар "Хубилай хаан тухайн үедээ улс төрийн төвийг Бээжинд шилжүүлэхдээ Хятадын нутагт суурьшиж байна гэж бодоогүй харин өнө эртнийхээ монгол газар, Монгол, Хятадын зааг нутагт шилжин суурьшлаа гэж үзэж байсан байх. Нөгөө талаар, хуучин нийслэлээ төрийн төв байлгасан бол урт удаан хугацаанд хятадууд Монгол руу шилжин суурьшиж, үндэстнийх нь хувьд уусгах аюул нүүрлэх байсан байж болох юм"⁶ гэжээ.

Мөн Монгол гүрний төвийг худалдааны их зам, далайн боомтод ойртуулах, хятадын хүн амын нөөц, эд агуурсын баялгийг, бусад газар орныг шинээр байлдан дагуулах явдалтай холбон үзсэн ч тал бий⁷.

Оюунлиг гэх ойлголтыг эрдэмтэд аль нэг нийгмийн нэг соёлд хамаарагдах хүмүүс байгалийн ба нийгмийн хүрээллээс шалтгаалж, өөрийгөө болон ертөнцийг үзэх үзэлтэй болж, тэр нь тухайн бие хүний ухамсар сэтгэхүйд тусгалаа олж, түүхийн

¹ Ч. Далай. Монголын түүх. \1260-1368\ УБ., 1992

² Г.Сүхбаатар. Монголын эртний түүх судлал, 3-р боть. Монгол Нирун Улс.УБ., 1992. 227-р тал

³ мөн тэнд 224-р тал

⁴ мөн тэнд 228-р тал

⁵ А. Амар. Монголын товч түүх. 189-р тал

⁶ Ж.Болдбаатар. Түүх зулсан он жилүүдийн ойллого. (Өгүүлэлүүдийн эмхтгэл). УБ., 2003. I боть 29-р тал

⁷ "БНМАУ-ын түүх" УБ., 1984 169-р тал

бодит үйл явцад нөлөөлдөг гэж тайлбарласан байна. Иймд XX, XXI зууны монгол хүн, XXIII зууны монгол хүний оюунлиг адил байх аргагүй. Одоогийн дэлхийн улс орнуудын хил хязгаар, дэлхий нийтийн дэг журам түүхэн урт хугацаанд улс үндэстэн, соёл иргэншил хооронд явагдсан зөрчил тэмцлийн дүнд бүрэлдэн тогтсон билээ.

Буурал түүхийн хуудсыг сөхвөл өнөөгийн умарт хятад нь хойт Азийн нүүдэлчин улс түмэн хийгээд хань үндэстэн төрт улсаа байгуулж, бие биетэйгээ булаалдан тэмцэлдэж байсан газар нутаг юм. Жишээлбэл, хань үндэстний байгуулсан Вэй, Зинь улс 389-589 онд, Сүй ба Тан улс 581-907 онд, умартын таван ханилаг улс гэгдэх хожуу үеийн Лян, Тан, Зинь, Хань, Жоу улс 907-960 онд, умарт Сун улс 960-1127 онд оршин тогтносон бол эдгээр төрт улсуудтай он цагийн хувьд зэрэгцэн, орон зай, газар нутаг булаалдан тэмцэлдэж байсан умартын нүүдэлчин угсаатны төрт улсуудыг нэрлэвээс тавгач нарын байгуулсан Умарт Вэй улс 368-534 онд, хятангийн Ляо улс 907-1125 онд, зөрчидийн Алтан улс 1115-1234 онд оршин тогтнохдоо өнөөгийн умарт хятадыг бүхэлд нь буюу хэсэгчилэн эзэгнэж байжээ⁸. Сурвалж бичигт тэмдэглэснийг үзвэл МЭӨ 74-49 оны үед нүүдэлчин аймгууд өмөнш их нүүдэл хийж, умарт хятадад суурьших болсон байна. Ялангуяа хүннү умарт ба өмнөд хэсэг болж хуваагдсанаас хойш МЭӨ 90 он гэхэд одоогийн умарт хятадад суурьшсан Хүннү нар 237 мянга болжээ. Хүннүгээс гадна ухуань, сяньби, ди, цян гэх нүүдэлчин аймгууд умарт хятадад руу нүүдэл хийв. Сяньби аймгаас мужун нар хүчирхэгжин 337-370 онд түрүү үеийн Янь улс, 398-410 онд хожуу үеийн Янь улс, 386-394 онд баруун Янь улс, өмнөд Янь гэх төрт улсаа байгуулж явжээ. Тавгач нарын Умарт Вэй улс 12 хааны нүүр үзэж, 148 жил оршин тогтнохдоо одоогийн умарт хятадыг бүхэлд нь эзэгнэсэн түүхтэй⁹. IV зуун гэхэд умарт хятад дахь нүүдэлчин үндэстэн угсаатны тоо нэг сая дөрвөн зуун мянга илүү болж, 311 онд хүннү цэрэг хятадын Зинь улсын нийслэл Лоян хотыг авч эзэн хаан Хуэй-диг олзолсон билээ.

Хожим монголтой угсаа гарвал нэг хятан аймаг хүчирхэгжиж байсан үедээ цэрэг дипломатын аргаар умарт хятадыг бүхэлд нь харьяандаа оруулсан юм.

Хятадын Тан улсын Минзун хуандийн хүргэн түрэг-шато угсааны Ши Зинтан гэгч хожуу үеийн Тан улсын самуунт байдлыг ашиглан умарт хятадын цагаан хэрэмнээс өмнө орших 16 тойрог газар нутгийг (одоогийн Бээжин хотоос Шаньси

⁸ Ван Минсунь. Юаньдай дэ ширэнь юй жэнжи. Тайбэй. 1992. 2-р тал

⁹ Хун Рэнюн. Жунго хунгуаньши. Тайбэй. 1998. 111-р тал

мужийн умарт хэсэг орно) хятанд найр тавин өгөөд бас хятан цэргийн дэмжлэгтэйгээр хожуу үеийн Тан улсыг мөхөөж бүр сүүлдээ Хятангийн хаан Елюй Дэгуаны хуурай хүү нь болсон юм. Эл явдал умарт хятад дахь хятангийн ноёрхолыг улам бататган өгчээ. Дээрх үйл явдлууд Хубилайг Юан гүрэн байгуулах тэр цаг үе хүртэл 400 жилийн турш нүүдэлчин улс түмэн умарт Хятадыг эзэгнэн суух нөхцлийг бүрдүүлж өгсөн ажээ¹⁰. Хятан нар 120 жил оршин тогтноод эцэс сүүлдээ дотоодын хямралд автан сульдаж доройтсоны улмаас хүчирхэгжин мандсан зөрчид болон Сун улсын нэгдсэн цэрэгт ялагдан мөхсөн билээ. Зөрчидийн байгуулсан Алтан улс хятадын Сун улсыг дайлан удаа дарааллан ялалт байгуулсаар 1127 онд нийслэл Кайфэнг авч эзэн хаан агсан Хуэй Зун, түүний орыг авсан дүү Чин Зун нарыг гэр бүлийн гишүүд, татвар эмс, ойр дотнын шадар хүмүүсийн хамтаар олзолсоноор 67 жил оршин тогтносон Умарт Сун улс мөхөх нь тэр¹¹. Мөн тэр жилдээ Сун улсын эзэн хааны гэр бүлээс гаралтай Жао Гоу гэгч өмнөд хятадад Өмнөд Сун улсыг байгуулж Линьань (одоогийн Ханжоу хот) хотыг нийслэлээ болгосон юм. Ингээд зөрчингүүд умарт хятадыг бүхэлд нь эзэгнэх болж Яньжин хотыг (одоогийн Бээжин) Дунд нийслэлээ болгон зуун хорь гаруй жил умарт Хятадад оршин тогтносон юм. Эл түүхт явдлаас хойш зуу гаруй жилийн дараа зөрчидийн Алтан улс 1234 онд Их Монгол Улстай хийсэн олон жилийн дайнд ялагдан мөхсөнөөр өнөөгийн умарт Хятад монголчуудын мэдэлд орсон түүхтэй.

Одоогийн Хятадын нийслэл Бээжингийн үүсэл түүхийг аваад үзэхэд одоогоос 2500-3000-аад жилийн тэртээ эртнийн хятадын баруун Жоу улсын үед хот суурин болж тухайн үедээ Зи гэсэн нэртэй байв. Хятадын түүхэн дэх Байлдаант улсын үед буюу одоогоос 2300 гаруй жилийн тэртээ Янь гэх ханлиг улсын нийслэл байгаад түүний дараа мянган жилийн туршид умарт хятадын стратегийн чухал түшиц хийгээд худалдааны гол төв байснаас биш алив нэг төрт улсын нийслэл болж байсангүй, харин X зууны эхээр хятангууд умарт хятададыг эзгнэхдээ одоогийн Бээжинг Ляо улсын 2 дахь нийслэл болгон Яньжин хэмээн нэрлэсэн билээ.

Чингис ба түүнийг залгамжлагч их хаадын үед монголчуудын эзлэн авсан газар нутаг, хүн ам, дайны олз, эд баялаг асар их нэмэгдэхтэй зэрэгцээд улс төрийн нөлөө, эрх мэдэл ч хязгааргүй өсч ертөнцийн талыг өөрийн арга, оюун ухаанаараа илбэн тохинуулсан билээ.

¹⁰ Фань Шүжи. Гоши Гайяо. Фүдань Дасюэ Чүбаньшэ. 2000. 207-р тал.

¹¹ Фань Шүжи Гоши гайяо. Фүдань Дасюэ Чүбаньшэ. 2000. 259-р тал

Чингис хаан монгол аймгуудыг нэгтгэж төр улсаа байгуулахдаа хамгийн түрүү өөрийн хөвгүүд дүү нартаа газар, харьяат иргэдийг соёрхон хувь хүртээхдээ уугуул монгол газар нутгаасаа эхэлсэн билээ. Гэвч гадагш чиглэсэн аян дайн өргөжихийн хирээр дараагийн ээлжинд эзлэн авсан газар нутаг, хүн амы нь хувь болгон хүртээх болов. Хүүхдүүд өрх тусгаарлахад аав ээж нь хувь болгож мал, хөрөнгөнөөсөө таслан өгч, өрх гэрий нь төхөөрч бие даалгадаг ёсон монголчуудын нүүдлийн амьдрал ахуйгаас үүдэлтэй. Хүүхдүүд бие даахаараа мал хөрөнгөө авч өвс устай бэлчээр нутаг бараадан тусдаа амьдрал ахуйгаа төвхнүүлдэг. Энэхүү ёс монголчуудын улс орныг засах хэрэг дээр ч илэрсэн юм. Дайны явцад эзлэн авсан аливаа бүгдийг эзэн хааны өмч хэмээн үздэг байлаа. Түүнд эзлэгдсэн орны газар нутаг, хот суурин, хүн ам, бүтээн байгуулсан эд баялаг бүгд орно. Хаан өөрийн хөвгүүд, ойр төрлийнхөн, гавьяат жанжин түшмэддээ уугуул монгол газар нутгаас хувь хүртээгээд зогсохгүй харь орны газар нутгийг мөн хуваан өгдөг байв¹². Үүнийг нотолсон мэдээ баримт Лувсанданзангийн "Алтан товч"-д бий: " Чингис хаан Жундугийн алтан, мөнгөн, эд агуурс, юмыг тоолуулахаар Үнгүр буурч, Архай хасар, Шихихутуг гурвуулыг илгээв. Эд гурвыг айсуй хэмээн Хада нэрт ноён эсрэг угтан¹³, алттай эрдэнэ агуурс бариад Жунду дотроос гарч эсрэг ирэв. Хадад Шихихутуг өгүүлсэн нь: Урьд Жундугийн эд, мөн Алтан хааных ажгуу за. Эдүгээ Чингис хааных буй за. Чингис хааны эд агуурсыг эчнээ яагаад хулган авчирч өгнө чи. Би үл авах хэмээн Шихихутуг эс авав. Үнгүр буурч, Архай хасар хоёр авав. Эд гурав Жундугийн эд агуурс юмыг жүсэн тоолж ирэв. Төдий Чингис хаан, Үнгүр, Архай хасар, Шихихутуг гурвуулаас, та нарт Хада юу өгөв хэмээн асуув. Шихихутуг өгүүлсэн нь: Урьд энэ Жундугийн эд Алтан хааных ажгуу. За. Эдүгээ Чингис хааных болов заа. Чи Хада Чингис хааны эдийг эчнээ хулгаж яахин өгнө хэмээж эс авав би. Үнгүр Архай хоёр өгснийг нь авлаа хэмээв. Чингис хаан, Үнгүр, Архай хоёрыг донгодов. Шихихутугийг их ёсон сэтгэжээ хэмээн их соёрхож үзэхийн минь нүд, сонсохын минь чих болж үлү аху чи хэмээн зарлиг болов"¹⁴ гэсэн байна.

¹² Захчид Сэцэн. Мэнгүү Вэньхуа юй Шэхуэй. Тайбэй. 1991. 154-р тал

¹³ Алтан улсын хаан монгол цэргээс зугтан Жундуг орхин гарахдаа Хада нэрт ноён сайд болгон үлдээжээ.

¹⁴ Лу. Алтан товч. УБ.1990. 131-132-р тал

Чингис хаан өөрийн үр ач нар, гавьяат жанжин, ноёд түшмэд, цэргүүд дайны олзноос зохих хувь хишиг хүртдэг ёсон нэгэнт тогтсон байсныг сурвалж бичигт тэмдэглэсэн байна. Чингис хаан Боорчи, Мухулай хоёрт соёрхол өгөхдөө хятад иргэнээс өмнө нь өгөөгүй байснаа дурьдаж хятадын жуйн иргэнийг Боорчи, Мухулай хоёрт тэнцүү хувааж өгөх, сайн хөвгүүдийг нь шувуу бариулж дагуулж явах, сайн охидыг нь өсгөж, эмсээ дагуулж, хормой засуулж явах тухай зарлиг буулгасан байдаг¹⁵. Хааны ураг төрөл хамгийн их хувийг хүртэнэ.

Монголчуудын байлдан дагуулал эхэлж өрнө зүг чиглэн түүний дүнд Чингисийн хөвгүүд Зүчи, Цагаадай, Өгэдэй нар хувь газар нутаг хүртэж яваандаа өөрсдийн улсаа байгуулцгааж өрх тусгаарлацгаасан билээ. Баруун зүг хийсэн аян дайны үр шимээс отгон хүү Тулуй хувь хүртэж хараахан амжсангүй. Харин Чингис хаан өмнө зүг хийх аян дайны явцад тэнгэрт хальсан агаад түүний хөвгүүн Өгэдэй, Гүюг, ач Мөнх нар түүний үйл хэргийг үргэлжлүүлж одоогийн хятадын газар нутаг хүн амыг эрхэндээ оруулсан. Иймд Тулуйнхны хувьд Хятадаас хувь хүртэх нь гарцаагүй болжээ.

Хубилайн эх Сорхугтани бэг Тулуйг өөд болсны дараа Өгэдэй хаанаас гуйж байгаад 1236 онд одоогийн хятадын Хэбэй мужийн Жэньдинд хувь газар авсан бол Хубилай 21 насандаа мөн 1236 онд хятадын Синжоуд түмэн өрхтэй хувь газар авч байсан ажээ¹⁶. 1251 онд Мөнх хаан ширээнд суусан нь Тулуйнханд шинээр эзэлж авсан хятад газраас хувь хүртэх өргөн боломж олгожээ. Жишээ нь, Мөнхийн ахмад хөвгүүн Асудай Вэй Хуэй газар (одоогийн Хэнань мужийн Шэ сянь) 3442 өрх, Мөнхийн дүү Хубилай Шаньсигийн Чанань сянь, Хуайжоу (одоогийн Хэнань мужийн Чинян сянь), Хубилайн ахмад хөвгүүн Чингэм Хуаймин газар (одоогийн Хэнань мужийн Чинян сянь нэг түм мянга хоёр зуун далан гурван өрх, Мөнх хааны) дүү Үлэгү Жан дэ газар (Хэнань мужийн Анян сянь) 25 056 өрх, Мөнх хааны дүү Мүгэ Хэнаньфү (Хэнань мужийн Лувэйян сянь) 5552 өрх гэх мэт газар нутаг, хүн амыг хувь болгон авчээ¹⁷. Мөнх Монгол улсын хаан болсныхоо дараахан дүү Хубилайгаа говиос өмнөх газар буюу хятад газрын хэргийг ерөнхийлэн шийтгэх түшмэлээр томилсон, Сун улсыг дайлах дайнаа үргэлжлүүлсэн зэргээс үзэхэд Чингисийн бага хүү Тулуйн үр сада

¹⁵ Сокровенное сказание монголов. Перевод С.А. Козина. Улан Удэ. 1990. 136-137-р тал

¹⁶ Г. Сүхбаатар. Монголын эртний түүх судлал. Монгол Нирун улс. УБ.1992. 228-р тал

¹⁷ Отаки Мацүво. Чингис хаан Хубилай хаан. Өвөрмонголын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо. 1986. 368-р тал

одоогийн хятадын газар нутаг, хүн ам хувь болон оногдож хятад газрын илбэн тохинуулах үүрэг түүхэн шалтгаанаар оногджээ.

Дээрх түүхэн нөхцөл байдлуудаас дүгнэлт хийхэд Хубилайн байгуулсан Юан гүрнээс өмнөх нэгэн мянга хоёр зуу гаруй жилийн хугацаанд өнөөгийн умарт хятадад хань үндэстний төрт улсууд бат бэх тогтвортой оршин тогтнож чадаагүй байна. Зарим үед умартын нүүдэлчин улс аймгуудын эрхшээлд орж, хятад хүн ам эсвэл өмнө зүг дүрвэх эсвэл тэдэнд дагаар орохоос аргагүйд хүрч байлаа. Хубилай хятад газрыг бүрэн эрхшээлдээ оруулж, одоогийн Бээжин хавьд Дайдү хэмээх хот байгуулах хүртэл умарт хятад нь 300 жил хойд Азийн нүүдэлчин улс аймгуудын эзэмшилд байсан явдал түүний оюунлигт мэдээж тусгалаа олсон нь лавтай биз ээ. Чингис хаан ч гэсэн Алтан улсын эсрэг хийсэн дайны явцад монгол цэрэг одоогийн Бээжин хотыг эзлэн авсан явдлыг Елюй Чүцайтай уулзахдаа тайлбарлаж "Ляо улс Алтан улс хоёр өнөд өстэй, эдүгээ Яньжин хот бидэнд сөхөрч, бид өшөөг тань авлаа" гэж хэлсэн байдаг¹⁸.

Хубилай одоогийн Бээжин хавьцаа Дайдү (Их нийслэл) хэмээх хот байгуулсан явдлыг тухайн үеийн цэрэг улс төр, эдийн засгийн зорилготой холбож үзэхээс аргагүй юм. Гэхдээ түүнийг Монгол улсын эрх ашгаас урвасан гэж үзэх үндэслэл алга. Харин одоогийн умарт хятад нь эрт үеэс умартын нүүдэлчин улс аймгууд, түүний дотор монголчуудын өвөг дээдэс гэж үзэж болох хүннү, ухуань, сяньби, мужун, хятан нар ээлж дарааллан суурьшиж, төр улсаа байгуулж байсан түүхэн нөхцөл байдал, тухайн цаг үе, нийгмийн нөхцөлд төлөвшин тогтсон ертөнцийг үзэх үзэл нь Хубилай хааныг ийм шийдвэр гаргахад нөлөөлсөн байна.

Abstract: *Kublai khan's decision to move Mongolian capital to China has been criticized by many scholars. Taking into consideration of early historical events happened in nowadays north china, as well as customs and universe concepts of Mongols, author tried to give explanation to his motivation*

¹⁸ Син Хань. Дамо Яньчэнь. Тайбэй., 1992. 69-р тал

Ном зүй:

Сурвалж бичиг:

1. Лу. Алтан товч. УБ.1990. 131-132-р тал.
2. Сокровенное сказание монголов. Перевод С.А. Козина. Улан Удэ.1990
3. Материалы по истории кочевых народов в Китае. 3-4 в.в. М., 1990 . Вып. №2, перевод В.С. Таскина.

Ном бүтээлүүд:

1. Ч.Далай. Монголын түүх. 1260-1368. УБ. 1992
2. Г. Сүхбаатар. Монголын эртний түүх судлал. Монгол Нирун улс. УБ.1992.
3. А. Амар. Монголын товч түүх. УБ. 1990
4. БНМАУ-ын түүх. УБ. 1984
5. Ван Минсунь. Юаньдай дэ ширэнь юй жэнжи. Тайбэй. 1992.
6. Хун Рэнюн. Жунго хунгуаньши. Тайбэй. 1998.
7. Фань Шүжи. Гоши Гайяо. Фүдань Дасюэ Чүбаньшэ. 2000.
8. Захчид Сэцэн. Мэнгү Вэньхуа юй Шэхуэй. Тайбэй. 1991. 154-р тал.
9. Син Хань. Дамо Яньчэнь. Тайбэй. 1992.
10. Отаки Мацүво. Чингис хаан Хубилай хаан. Өвөрмонголын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо. 1986
11. Ж.Болдбаатар. Түүх зулсан он жилүүдийн ойллого. УБ., 2003. I боть